



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/11/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424

Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866

Цахим хаяг: nbunchin0719@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	8
2.8.2 Авлага	8
2.8.3 Бараа материал	9
2.8.7 Үндсэн хөрөнгө	9
2.8.8 Өр төлбөр.....	10
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	11
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	14
2.12. Шилэн дансны мэдээлэл	14
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	14
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	14
1. Менежментийн захидал	15
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	16
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	20
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	23
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.03.25 № 1/374

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Г ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.ЦЭДЭНСОДНОМ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Өлзийт сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Өлзийт сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өлзийт сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

• 005020310

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Өлзийт сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Цэдэнсодном танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-т заасны дагуу Өлзийт сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-ноос 2020 оны 03 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэв.

Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 20 -ны өдрийн 1/60 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.-

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Өлзийт сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Өлзийт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	2	4	-	2	-
	Дүн	2	4	-	2	-

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Өлзийт сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг аудитор гүйцэтгэлээ.

Өлзийт сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэн 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2414319.6 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 24143.2 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2614388.8 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 26143,9 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас төлөвлөлтийн шатанд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг татсантай холбоотой байна.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллага аудитад хамрагдсан байна. Үүнээс:

№	Байгууллагын нэр	Дүгнэлтийн хэлбэр	Аудитад хийсэн байгууллага нэр
1	ЗДТГ	Зөрчилгүй	
2	Эрүүл мэндийн төв	Зөрчилгүй	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
3	Ерөнхий боловсролын сургууль	зөрчилгүй	"Хонгорын үр сад" аудит
4	Цэцэрлэг	Зөрчилгүй	"Хонгорын үр сад" аудит
5	ИТХ	Түүвэрт хамрагдсан	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
6	Соёлын төв		
7	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
8	Сум хөгжүүлэх сан		

Өлзийт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ 2018 оны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийн дагуу 2019 оны эхэнд бараа материалын бусад нөөц бүртгэлтэй материалыг хангамжийн материал руу шилжүүлсэн байна. Үүнд соёлын төв 277.5 мянга, ЕБС 5063.6 мянга, цэцэрлэг 548.4 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн байна. Мөн эрүүл мэндийн төвийн тусгай зориулалтын материалд бүртгэлтэй 11856.5 мянган төгрөгийн материалыг хангамжийн материалд шилжүүлж залруулсан байна. Сум хөгжүүлэх сангийн 165709.8 мянган төгрөгийн зээлийн авлагыг оны эхэнд дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага гэж бүртгэснийг хувь хүмүүсээс авах авлага гэж залруулсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

ТТЗ-чийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар акт тогтоогоогүй, албан шаардлага өгөгдөөгүй.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд орон нутгийн хөгжлийн сангаас тухайн онд хэрэгжсэн төсөл хөтөлбөр арга хэмжээнээс сумын төвийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн 85900.0 мянган төгрөгийн ажлаас урьдчилгаа санхүүжилт олгосон 60130.0 мянган төгрөгийг тайланд авлагаар тусгаагүй байсныг залруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчил

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 39.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Төсвийн шууд захирагчийн тайланд илэрсэн алдаа, зөрчил /сая.төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс					
		Тоо	Дүн	Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ИТХ	2	6.0	1	5.3	1	0.7		
2	ЗДТГ	2	5.3	1	4.8	1	0.5		
3	Ерөнхий боловсролын сургууль	1	0.7			1	0.7		
4	Цэцэрлэг	1	1.3			1	1.3		
5	Эрүүл мэндийн төв	1	2.3			1	2.3		
6	Соёлын төв	2	2.2			1	0.6	1	1.6
7	Сум хөгжүүлэх сан	1	22.04			1	22.04		
8	Орон нутаг хөгжүүлэх сан								
	ДҮН	10	39.84	2	10.1	7	28.14	1	1.6

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 136531.1 мянга, эцсийн үлдэгдэл 169594.9 мянган төгрөг болж 33053.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Эцсийн үлдэгдлийн эзлэх хувь
Орон нутгийн ерөнхий орлого	17986.6	56356.6	38370.0	33.2
ОНХС	46868.5	39080.8	-7787.7	23.0
Сум хөгжүүлэх сан	71685.9	74157.5	2471.6	43.8
Дүн	136541.0	169594.9	33053.9	100,0

Эх сурвалж: Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 169594.9 мянган төгрөг нь дээрх дансанд байршиж байна. Үүнээс Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 56356.6 мянган төгрөгийн үлдэгдлээс 1014.9 мянган төгрөг нь оны эцэст төсөвт байгууллагуудад орон нутгийн орлогоос санхүүжүүлсэн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн, 55341.7 мянган төгрөг нь урьд оны зарцуулаагүй үлдэгдэл болон тайлант оны татварын орлогоос төвлөрсөн орлого байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 179418.1 мянга, эцсийн үлдэгдэл 239013.5 мянга төгрөг олж 59595.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.9	63.3	61.4
Байгууллагаас авах авлага	13706.4	72416.4	58710.0
Хувь хүмүүсээс авах авлага	165709.8	166533.8	824.0
Дүн	179418.1	239013.5	59595.4

Эх сурвалж: Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оноос 59595.4 мянган төгрөгөөр өссөний гол шалтгаан нь орон нутгийн хөгжлийн сангийн 58810.0 мянган төгрөгийн авлага өссөнтэй холбоотой байна. Энэ нь аудитаар сумын ерөнхий төлөвлөгөөний урьдчилгаа санхүүжилт 60130.0 мянган төгрөгийг авлагаар тусгаснаас шалтгаалжээ.

2.8.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 323437.5 мянга, эцсийн үлдэгдэл 365704.5 мянган төгрөг болж, 42267.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	199609.9	212101.9	12492.0
Бичиг хэргийн материал	6302.8	4901.3	-1401.5
Эм боох материал	1760.7	5827.6	4066.9
Аж ахуйн материал	28620.4	26411.2	-2209.2
Сэлбэг хэрэгсэл	823.0	1053.0	230.0
Барилгын засвар	3016.0	3670.0	654.0
Түлш, шатах тослох материал	33.4	1736.0	1702.6
Хүнсний материал	343.3	149.5	-193.8
Бусад хангамжийн материал	67038.5	94754.0	27715.5
Мал амьтад	10000.0	15100.0	5100.0
Нөөцийн бараа	5889.5		-5889.5
Дүн	323437.5	365704.5	42267.0

Эх сурвалж: Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд хандив тусламж 28249.5 мянга, төсвийн хөрөнгөөр 351397.5 мянган төгрөгийн бараа материал авч, данс хооронд 17746.0 мянган төгрөгийн бараа материал шилжүүлж, 26605.2 мянган төгрөгийн бараа материал акталж 26605.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Хүснэгт №3.1 материалын дэлгэрэнгүй /мянган төгрөг/

№	Байгууллага	Бараа материал								
		Эхний үлдэгдэл	нэмэгдсэн			Бүгд	хасагдсан		Бүгд	Эцсийн үлдэгдэл
			Төсвийн хөрөнгөөр	Хандив тусламжаар	бусад		Худалдан зарцуулсан	бусад		
1	ИТХ	2815.1	10681.8		458.0	11139.8	10136.3	673.6	10809.9	3145.0
2	ЗДТГазар	70061.3	59086.8	24916.0		84002.8	54883.4	10634.9	65518.3	88545.8
3	Сургууль	120388.6	146708.0	195.0		146903.0	128962.6	416.5	129379.1	137912.5
4	Цэцэрлэг	75594.8	48446.8		2255.9	50702.7	40220.0	7196.0	47416.0	78881.5
5	Соёл	24269.0	9486.6			9486.6	4322.7	5421.2	9744.0	24011.6
6	ЭМТөв	30308.7	76987.4	3138.5		80125.9	74963.8	2263.0	77226.8	33207.8
	Дүн	323437.6	351397.5	28249.5	2713.9	382360.9	313488.8	26605.2	340094.1	365704.4

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5992147.5 мянга, эцсийн үлдэгдэл 7297733.7 БНА-2020/11/СТА-ТТЗ

мянган төгрөг болж, 1305586,2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	5,013,894.7	6,033,237.8	1,019,343.2
Тээврийн хэрэгсэл	201,051.8	266,606.0	65,554.2
Машин тоног төхөөрөмж	375,458.9	495,797.2	120,338.4
Тавилга эд хогшил	293,150.7	393,501.2	100,350.5
Дуусаагүй барилга, байгууламж	7,400.0	7,400.0	0.0
Номын фонд	10,790.4	10,790.4	0.0
Бусад үндсэн хөрөнгө	26,965.2	26,965.2	0.0
Программ хангамж	3,134.0	3,134.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	60,301.8	60,301.8	0.0
Дүн	5,992,147.5	7,297,733.7	1,305,586.2

Эх сурвалж: Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 69073.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүй, хандив тусламжаар 1497026.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн ба ЗДТГ, ИТХ-аас 10000.0 мянган төгрөгийн автомашин шилжүүлэн авсан, 233178.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан, 37334.6 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлж оны эцэст 7297733.7 мянган төгрөгийн үндсэн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт №4.1 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй /мянган төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Төсвийн болон өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр худалдаж авсан	Үнэ төлбөргүй хандив, тусламжаар авсан	Шилжүүлэн авсан	Акталсан	Балансаас баланс-д шилжүүлж өгсөн	Эцсийн үлдэгдэл
Сургууль	1,666,570.8	26,691.2	54,268.5		25,073.7	0.0	1,722,456.7
Цэцэрлэг	983,796.7	4,570.0	1,172,434.9		7,318.7		2,153,482.9
Эрүүл мэндийн төв	611,537.2	12,970.0	0.0		11,190.2		613,317.0
Соёлын төв	353,469.6	0.0	24,524.2		19,121.9		358,871.8
ИТХ	13,176.8	6,519.0	39,031.6		3,400.1	12,834.6	42,492.7
ЗДТГ	2,363,596.4	18,323.0	206,767.1	10,000.0	167,074.0	24,500.0	2,407,112.5
Дүн	5,992,147.5	69,073.2	1,497,026.2	10,000.0	233,178.6	37,334.6	7,297,733.7

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 7072.7 мянга, эцсийн үлдэгдэл 7214.7 мянган төгрөг болж, 142.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	7072.7	7214.7	142.0
Ажилчидтай холбогдсон өглөг	266.9	469.5	202.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	6805.8	6745.2	-60.6
Нийт дүн	7072.7	7214.7	142.0

Эх сурвалж: Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцсийн өглөгийн 93.5 хувийг бараа ажил үйлчилгээний зардлын өглөг эзэлж байна. Тухайлбал:

- ЕБС нь тухайн тайлант онд шинээр түлш халаалтад 6745.2 мянган төгрөгийн өглөг үүссэн байна. Энэ нь сургуулийн өмнөх боловсролын Өлзийт сумын 75 хүүхдийн шинэ цэцэрлэгийн барилга 2019 онд ашиглалтад орж ашиглахгүй байгаа хуучин цэцэрлэгт Ерөнхий боловсролын сургуулийн насан туршийн боловсролын үйл ажиллагаа явуулахдаа цэцэрлэгийн батлагдсан төсвөөс 6745,2 мянган төгрөгийн халаалтын зардлыг төлснийг “Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгох өнөөгийн байдал үр дүн”-д хийсэн аудитаар акт тогтоосон төлөгдөөгүй байна.
- Соёлын төв нь 469.5 мянган төгрөгийн цалингийн өглөг шинээр үүссэн байна.

Хүснэгт 5.1 Өглөгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

№	Төсвийн захирагч	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:	
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллага хоорондын
1	Сургууль	263.8	6745.2		6745.2
3	Соёлын төв		469.5	469.5	
4	ИТХ	258.5			
5	ЗДТГ	6538.6			
6	Эрүүл мэндийн төв	11.9			
	Дүн	7072.7	7214.7	469.5	6745.2

Эх сурвалж: Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5899618,0 мянга, эцсийн үлдэгдэл 5813753,3 мянган төгрөг болж, 85864,8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн дансны бууралтаас шалтгаалжээ.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	2,023,410.4	2,023,410.4	-	29.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,675,109.5	2,675,109.5	-	38.5
Хуримтлагдсан үр дүн	947,717.2	2,246,151.6	1,298,434.4	32.4
Дүн	5,646,237.1	6,944,671.5	1,298,434.4	100.00

Эх сурвалж: Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын капитал данс, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд өөрчлөлт ороогүй ба хуримтлагдсан үр дүн нь тайлант хугацааны үр дүнгээр өссөн байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2018 оны төсөв батлах тухай 10/03 дугаар тогтоолд зааснаар Өлзийт сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 8300.0 мянга, аймгийн төсөвт 101600.0 мянга, нийт 109900.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 108470.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 98.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого / мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	8300	5648.6	-2651.4	68.1

**Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	3000	2653	-347	88.4
1.2.Нэмэгдсэн өртгийн албан татвар	4000	2320.3	-1679.7	58.0
1.3.Агаарын бохирдлын төлбөр	1300	675.3	-624.7	51.9
2.Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	101600	102821.8	1221.8	101.2
2.1.Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	88000	88442	442	100.5
2.2.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2100	2176	76	103.6
2.3.Газрын төлбөр	3000	2824.5	-175.5	94.2
2.4.Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	8500	9379.3	879.3	110.3
Нийт дүн	109900	108470.4	-1429.6	98.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 68.1 хувиар биелүүлж 31,9 хувиар тасарсан нь нэмэгдсэн өртгийн албан татвар 1679.7 мянга, агаарын бохирдлын татвар 624.7 мянга, аж ахуй нэгжийн орлогын албан татвар 347.0 мянган төгрөгөөр дутуу орлого төвлөрсөнтэй холбоотой байна. Аймагт төвлөрүүлэх орлогыг 101.2 хувиар биелүүлж 1.2 хувиар орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2018.12.17-ний өдрийн 15/02 тоот тогтоолоор сумд төвлөрөх татварын орлогыг 94700.0 мянга, татварын бус орлогыг 25000.0 мянга, ТБӨ-г 600.0 мянга нийт 120300.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 181442.0 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 150.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Сумын орон нутгийн орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	94,700.0	144,571.2	49,871.2	152.7
1.1.ИОТХ	9,000.0	11,897.0	2,897.0	132.2
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	16,000.0	18,371.0	2,371.0	114.8
Хөрөнгийн Орлого		12,888.0	12,888.0	
1.4. Бууны татвар	2,900.0	2,528.0	-372.0	87.2
1.5.Улсын тэмдэгийн хураамж	2,500.0	11,695.7	9,195.7	467.8
1.6.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	4,000.0	4,235.0	235.0	105.9
1.7.ТТАМАТөлбөр	12,000.0	12,128.5	128.5	101.1
1.8 Ан агнуур	48,000.0	67,882.2	19,882.2	141.4
Бусад Татвар		2,419.8	2,419.8	
1.9 Нохойны татвар	300.0	526.0	226.0	175.3
2.Татварын бус орлого	25,000.0	30,470.8	5,470.8	121.9
2.1 Хүү торгуулийн орлого	25,000.0	30,470.8	5,470.8	121.9
ТБӨ	1,100.0	6,400.0	5,300.0	581.8
Нийт дүн	120,800.00	181,442.00	60,642.00	150.2

Эх сурвалж: Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2485503.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2344839.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 140663.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1426977.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 38465.1 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 725296.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 93795.0 мянган төгрөгийг

орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 82924.4 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 118544.4 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг бүрэн авч, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 6669.1 мянга дутуу авсан байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор 81924,1 мянган төгрөг оруулахаас 68160.5 мянган төгрөг оруулж, батлагдсан төсвөөс 13763,5 мянган төгрөгөөр орлого дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь сум хөгжүүлэх сан 81324.1 мянган төгрөгөөс 56981.5 мянга, Орон нутгийн хөгжлийн санд орлого төлөвлөөгүй ба гүйцэтгэлээр өвсний үнэ, түрээсийн төлбөр, нөхөрлөлийн гэрээний төлбөрөөс 10079.0 мянган төгрөг төвлөрсөн, соёлын төв 500.0 мянган төгрөгөөс гүйцэтгэлээр 500.0 мянга, ЗДТГ 600.0 мянган төгрөгөөс 600.0 мянга тус тус төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2345403.8 төгрөг буюу 94.4 хувьтай байгаа нь эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 2185.6 мянга, хоол хүнс 3339.9 мянга, тээвэр шатахууны зардал 3913.3 мянга, сум хөгжүүлэх сангийн тайлант онд 153000.0 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн боловч 54500.0 мянган төгрөгийн зээл олгож бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 98500.0 мянган төгрөгөөр зарцуулаагүй гарсан зэрэг нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Хүснэгт 10. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	73,311.9	73,291.1	(20.8)	100.0
Засаг даргын Тамгын газар	362,720.8	361,913.1	(807.7)	99.8
Ерөнхий боловсролын сургууль	981,306.3	976,450.3	(4,856.0)	99.5
Цэцэрлэг	282,479.6	282,390.8	(88.8)	100.0
Соёлын төв	63,560.7	63,546.6	(14.1)	100.0
Эрүүл мэндийн төв	428,460.2	421,650.2	(6,810.0)	98.4
Сум хөгжүүлэх сан	153,000.0	54,500.0	(98,500.0)	35.6
Орон нутгийн хөгжлийн сан	140,663.5	111,661.7	(29,001.8)	79.4
Нийт дүн	2,485,503.0	2,345,403.8	(140,099.2)	94.4

Эх сурвалж: Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсөв: Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 5237.3 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 40711.4 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр олгож бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангилалд зарцуулах эрхийг нээж олгосон бөгөөд 44393.3 мянган төгрөгийг зарцуулж 1555.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 11. Нэмэлт төсвийн судалгаа /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Санхүүжилт	Зарцуулалт
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	7371.2	7367.0
Засаг даргын Тамгын газар	33555.2	32042.1
Эрүүл мэндийн төв	34.8	
Ерөнхий боловсролын сургууль	3237.3	3237.3
Соёлын төв	1749.0	1746.9
Цэцэрлэг	1.2	
Нийт дүн	45948.7	44393.3

Эх сурвалж: Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал
Байхгүй

2.12. Шилэн дансны мэдээлэл

Өлзийт сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан
126 мэдээллийг хугацаанд нь, 17 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	3	14	11	1	2
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	7	1	
4	Сар бүр	5	60	52	8	
5	Тухай бүр	5	60	53	7	
6	Нийт	18	145	126	17	2

Худалдан авах ажиллагааны тайланг /бүтэн жилээр мэдээлэх/, улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл 3-р улирал, 9 сар, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 3-9 сар, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр) 1-9 сар, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 1-9 сар, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) 3 сард тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэсэн ба 2 зөвлөмж өгч хариуг Өлзийт сумын Засаг даргын 2020 оны 5 сарын 10-ны өдрийн 46 дугаар тоотой зөвлөмжийг хэрэгжүүлсэн ажилласан тухай хариуг ирүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Өлзийт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Өлзийт сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

1. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Өлзийт сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 39.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 28.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 10.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Мөн цалингийн зардлаасаа ИТХ 700.0 мянга, хүн эмнэлэг, 2352.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон, ЕБС сахилгын шийтгэлтэй ажилтанд 775.9 мянган төгрөгийн урамшуулал олгосон, Соёлын төв түлш халаалтын зардлаасаа ажилчдад 660.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон, шүүхийн шийдвэрээр Д.Нямсүрэнд эрхлэгчийн 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 31 тоот тушаалаар ажилгүй байсан хугацааны цалинг 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 131/ШШ2019/00901 тоот шүүхийн шийдвэрийг үндэслэн 1673,2 мянган төгрөг олгосон, сум хөгжүүлэх сангаас олгосон эргэн төлөлтийг хугацаанд барагдуулаагүйгээс 21 зээлдэгчийн 64730.1 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

3.1.2 Эрсдэл: Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан үнэн зөв нэгтгэгдэхгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хөрөнгө шамшигдуулах.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулан, авлагыг барагдуулж, Төсвийн тухай хуульд заасан эрхээ бүрэн хэрэгжүүлж цаашид гаргасан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	639,386,805.84	774,312,826.86
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	136,531,069.45	169,594,930.90
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	136,531,069.45	169,594,930.90
3121	Төгрөг	136,531,069.45	169,594,930.90
31211	Төрийн сангийн харилцах	136,531,069.45	169,594,930.90
33	АВЛАГА	179,418,185.00	239,013,536.09
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,949.00	63,284.09
335	Бусад авлага	13,706,400.00	238,950,252.00
